



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН**

2023 ОН

АГУУЛГА

Нэг.Зорилт	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/.....	3
Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа	8
4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :	8
4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:.....	10
4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:.....	11
4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа	13
4.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн талаар	16
Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа	17
Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд	18
Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд /	19
Найм. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд	20
Ес. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд	22
Арав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/	24
Арван нэг. Идэвх санаачлага, шинэлэг ажил.....	28

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг.Зорилт

Тус хэлтэс нь 2023 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Хэлтсийн 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэд хөдөлмөрчдөд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах, иргэд үйлчлүүлэгчдэд эрх зүйн сургалт зохион байгуулах, улсын бүртгэгч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Мөн улсын бүртгэгч нарын хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилага ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх үүднээс төвийн улсын бүртгэгч нарыг сэлгээн ажиллуулах хуваарыг хэлтсийн даргаар батлуулан хариуцлагыг өндөржүүлэн ажиллаж байна.

Иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр гарын авлага болон бусад материалаар хангаж, бүртгэлийн бүрдүүлбэр хангуулсны үндсэн дээр мэдүүлэг хүлээн авах ажиллагаанд улсын бүртгэгчдийг сургасан болно.

Сумдын улсын бүртгэгч нарыг өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх, хийсэн бүртгэлийг тухай бүр цахимжуулах, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, цаг ашиглалтанд байнгын хяналт тавин ажиллаж байгаа ба өглөө бүр Spark дотоод сүлжээгээр ирцийн бүртгэлийг хянаж байна. Мэдээлэл шуурхай солилцох үүднээс телеграммаар ирсэн мэдээлэл, үүрэг чиглэлийг сумын улсын бүртгэгч нарт шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон сумын ЗДТГ-ын даргаас цаг бүртгэлийн хуудсыг авч хэвшсэн болно.

Цахим хуудсанд болон нийгмийн сүлжээний байгууллагын фэйсбук хуудсанд холбоо барих утасны дугаар, цахим шуудан хаяг, цагийн хуваарийг шинэчлэн оруулсан нээлттэй утаснуудыг бичсэн.

Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх, гадаад паспортуудыг эздэд нь утсаар мэдэгдэж үйлчлүүлэгчидтэй эргэх холбоотой ажиллаж байна. 16 нас хүрээгүй хүүхдийн паспорт олгохдоо “Хилээр гарах тохиолдолд төрсний гэрчилгээг хамт авч явах тухай санамж” бичиг хавсаргаж өгч үйлчилж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 1/602 тоотой ирүүлсэн чиглэлийг ИУБГ-аас хүлээн авч иргэний бүртгэлийн тасгийн болон сумдын улсын бүртгэгч нарт танилцуулан онлайн хурал зохион байгуулж ирсэн иргэдийн мэдээлэлийг тухай бүр шалгаж зөрчил арилгаж ажиллахыг үүрэг болгосон.

1. Хаягийн мэдээлэл, гэр бүлийн гишүүдийн мэдээлэл шалгах программ ашиглалтанд орсоноор иргэд өөсдийн хаягаа шалган тухай бүр ирж шалгуулж байгаа ба хаягийн зөрчилтэй болон давхар бүртгэгдсэн бүртгэлүүдээ тухай бүр шилжилт хөдөлгөөний бүртгэлээр зөвтгүүлж ажилласан.

2. Хүүхдийн мөнгө болон зөрчилтэй иргэдийн талаар аймгийн Халамж, Статистик, Өлгий сумын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдийг урьж оролцуулан өргөтгөсөн хурал зохион байгуулж зөрчилтэй иргэдийн мэдээллийг сум баг тус бүрээр гаргаж хүргүүлэн зөрчил арилгах ажлыг зохион байгуулав.

3. Хаягийн мэдээллийг шалгасан зөрчлийг арилгасан, шийдвэрлэсэн талаархи мэдээллийг сумдаас авч нэгтгэн ТГ-т өдөр тутам 16 цагт хүргүүлэн ажиллаж байсан.

4. Аймгийн радио, телевизд иргэд хаягийн мэдээллийг хэрхэн шалгаж зөрчлөө хэрхэн арилгуулж ажиллах талаар ярилцлага өгч мэдээлэл хүргүүлж байсан болно.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4/363 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу үндэсний энгийн гадаад паспортын үйлчилгээний ачаалал ихсэж нэмэгдсэнтэй холбоотойгоор үйлчлүүлж буй иргэдэд хүндрэл учруулахгүй бүртгүүлэх иргэний хүсэлтийг шуурхай, хүнд сурталгүй, чирэгдэлгүй тухай бүр шийдвэрлэж, баталгаажуулалтыг тухай бүр хийх, эрх бүхий албан тушаалтан гадаад паспортыг сайтар шалгаж, аливаа ашиг сонирхолын зөрчилөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, үйлчилгээг шуурхай үзүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Манай аймгийн хувьд гадаад паспортын бүртгэл өдрөөс өдөрт нэмэгдэж одоогоор эхний хагас жилийн байдлаар 10000 гаруй иргэн цахим болон энгийн гадаад паспортын захиалга өгөөд байна. Мөн ИУБГ-ын даргын 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 3/3164 тоот чиглэлд заагдсан 16 заалтыг өдөр тутам мөрдлөгө болгон ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээс 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 3/3791 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлд төвийн болон сумдын улсын бүртгэгч, архивч нарыг оролцуулан хэлтсийн даргын хамт онлайн хурал зохион байгуулав. Уг хурлаар чиглэлд заагдсан лавлагаа болон иргэний үнэмлэх олгосон хуудсыг 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн хэвлэхгүй өгсөн үүрэг чиглэлийн дагуу

ажиллахыг нийт улсын бүртгэгч нарт анхааруулав. Мөн энэ чиглэлийн дагуу хийгдэсэн ажлын талаар 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн дотор бүх бүртгэгч нараас илтгэх хуудсаар хүлээн авсан. Ирсэн чиглэлийн дагуу иргэний үнэмлэх олголтын бүртгэлийг хэвлэхгүй, мэдээллийн санд олгосон тухай түүх үүсгэж бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн хоблогдох иргэнээр гарын үсэг зуруулан баталгаажуулж өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл гараагүй урд өмнөхөөсөө хялбар болсон талаар улсын бүртгэгч нар илтгэх хуудастаа бичиж ирүүлсэн байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, анхааруулга болон үүрэг даалгаврыг тухай бүрт нь улсын бүртгэгч нарт хүргүүлэн хэлтсийн дарга болон хяналтын байцаагчийн хамт онлайн хурлыг 7 хоног болгон зохион байгууллан холбогдох хууль журмын хүрээнд ажиллан өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хийж гүйцэтгэх, иргэдэд ямар нэгэн хүнд суртал гаргаалгүй ажиллахыг тогтмол үүрэг болгон ажиллаж байна.

Иргэний бүртгэлийн газраас 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн жагсаалтаар ирүүлсэн нэг хаягт 10 дээш иргэн бүртгэлтэй хаягаас манай аймгийн төвийн Өлгий сумын 162 хаягт 1918 иргэн бүртгэлтэй байна. Уг жагсаалтыг 2023 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн жагсаалтаас тус аймагт бүртгэлтэй хаягт байгаа иргэдийн судалгааг улсын бүртгэгч нараар гаргуулан Өлгий сумын багийн Засаг дарга нарын хамт тухайн хаягт амьдарч байгаа иргэдэд мэдэгдэн буруу орсон бол ХУБ-ын дүгнэлтээр нэмэлт өөрчлөлт оруулах болон шилжилт хөдөлгөөний бүртгэлээр хаяг зөвтгөх ажлыг хийж байна.

Нэг хаягт 10 дээш иргэн бүртгэлтэй 162 хаягт амьдарч байгаа 1918 иргэнээс өөрийн хаягт оршин сууж амьдардаг 1586 иргэн байна. Үлдсэн 332 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлээр хаягийн зөрчлийг арилган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн телеграммаар ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

1.Иргэний улсын бүртгэлийн мэдээлийн санд биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ хоёроос дээш удаа бүртгэсэн,хурууны хээ шалгагдаагүй алдааны төлөвтэй 7 иргэний жагсаалтыг мэдээллийн сангаас шалгаж 1 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл баталгаажиж иргэний үнэмлэх нь гарсан,6 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлж дүгнэлт гарсан боловч дүгнэлт нь баталгаажаагүй байна

2. Регисртийн дугаар өөрчилсний бүртгэл / ИУБ-25 / хоёроос дээш удаа бүртгэсэн, хурууны хээ шалгагдаагүй алдааны төлөвтэй 31 иргэний жагсаалтыг мэдээллийн сангаас шалгаж 27 иргэний Регисртийн дугаар өөрчилсний бүртгэл нь давхар бүртгэгдсэн төлөвийг хүчингүй болгуулахаар хяналтын улсын байцаагчид шилжүүлж 3846 дугаартай дүгнэлт гаргуулсан. 4 иргэний мэдээлэл мэдээллийн санд хүчингүй төлөвтэй байна.

3. Төрсний бүртгэл, үрчилсний бүртгэл, ОНӨ-ний бүртгэл, шилжин ирсний нийт 9 бүртгэлүүд бүртгэсэн төлөвтэй байсныг шалгаж, үүний дагуу жагсаалт

гарган ХУБ-д танилцуулж, төрсний 2 бүртгэл, үрчилсний 1 бүртгэл, ОНӨ-ний 1, шилжин ирсний 2 бүртгэлийг хүчингүй болгуулахаар, мөн үрчилсний 2 бүртгэл, шилжин ирсний 1 бүртгэлийг баталгаажуулахаар дүгнэлт гаргуулсан болно.

2023 онд 16, 25, 45 насанд хүрсэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр хамрагдах иргэдэс, иргэний үнэмлэх шинээр авах, дахин авах, сольж авахад бүрдүүлэх материал, иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлнэ зэрэг анонс хийж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.



Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 6/277 тоот албан бичгээр ирүүлсэн хугцаатай үүрэг чиглэлийн дагуу хэмжээ давхар, тексттэй файл дахь жагсаалтад дурдагдсан эд хөрөнгийн талбайн хэмжээ давхар тексттэй 8 бүртгэлийг 2022 оны 1500 дугаартай дүгнэлт болон эх нотлох баримтийг үндэслэн засвар өөрчлөлт оруулж зөрчилийг арилгасан Мөн УБЕГ-ын ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн 2022.11.08-ны өдрийн 6/9582 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс зөрүүтэй, хуулийн этгээдийг иргэн төлөвтөй, хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэгдсэн 389 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн засвар өөрчлөлтийг оруулж зөрчлийг арилгасан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн үнэ ороогүй газар өмчлөх эрхийн 144, үл хөдлөх эд хөрөнгө 98 бүртгэлийг эх нотлох баримтад үндэслэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 зүгээр зүйлд заасан үнийг улсын бүртгэлийн дугаарын арын мөрөнд бичиж хүргүүлэв. УБЕГ-аас ирүүлсэн 2023.01.18, 23-ны өдрүүдийн хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичгээс хаягийн зөрүүтэй 4 иргэний мэдээллийн зөрчилийг арилгаж шийдвэрлэв.

Иргэд хоорондоо худалдах, худалдан авах гэрээ хийсэн боловч өөрийн нэр шилжүүлэх бүртгэл хийлгээгүй 2, аль дээр оны өмнө байшингаа нураасан боловч эрхийн улсын бүртгэлээ хаалгаагүй 3 иргэний бүртгэлийг газар дээр нь шуурхай шийдвэрлэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг шалгуулахаар ирсэн иргэдийн хүсэлтийг ерэг системээс тухай бүр шалгаж мэдээллээр ханган зөвлөн тусалж ажиллав.

УБЕГ-ын ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн 2023.03.02-ны өдрийн 5/1854 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаартай дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн хавсралт файлд дурдагдсан Баян-Өлгий аймагт хамаарах засвар өөрчлөлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

Эрхийн улсын бүртгэлийг цахимжуулахаас өмнө Өмчилсөн төлөвтэй хувийн хэрэг хаах үйлчилгээ, тексттэй файл дахь жагсаалтад дурдагдсан эд хөрөнгийн хувийн хэрэг хаах үйлчилгээ тексттэй 2 бүртгэлийг хувийн хэрэг болгож эх нотлох баримтийг үндэслэн засвар өөрчлөлт оруулж зөрчилийг арилгасан

Эрхийн улсын бүртгэлийг цахимжуулахаас өмнө Өмчилсөн төлөвтэй хувийн хэрэг хаах үйлчилгээ, тексттэй файл дах жагсаалтад дурдагдсан эд хөрөнгийн Өмчилсэн төлөвтэй тексттэй 49 бүртгэлийг Бүртгэл хүчингүй болсон төлөвтэй болгож эх нотлох баримтийг үндэслэн засвар өөрчлөлт оруулж зөрчилийг арилгасан


УБЕГ-ын ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн 2023.05.01-ны өдрийн 5/4053 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дугаартай дүгнэлт болон эх нотлох баримтад үндэслэн хавсралт файлд дурдагдсан Баян-Өлгий аймагт хамаарах засвар өөрчлөлтийн ажлыг хийж гүйцэтгэв.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /ePRS/ дахь газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн жагсаалтыг нягтлан шалгахад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлсэн газрын эрхийн улсын бүртгэлд газрын зориулалтыг “Эзэмших”, “Ашиглах” гэж буруу оруулсан хавсралт файлд дурдсан г0213006445, г0213000828, г0213003202, г0213000975, г0213002933, г0213001160, г0213002578, г0207000450 тоот улсын бүртгэлийн дугаартай хувийн хэрэгүүдийн эх нотлох баримтийг үндэслэн тухайн газрын эрхийн улсын бүртгэлийн зориулалтыг гэр бүлийн хэрэгцээний болгож зөвөтгөн засвар өөрчлөлтийг оруулж, зөрчлийг арилгасан болно.


Мэдээллийн санд цахимжуулалтын үеэр буруу цахимжсан, төлөв буруу сонгосон хувийн хэргүүдийг эх нотлох баримт болон цаасан нотлох баримттай нь тулган шалгаж, Улсын байцаагчийн 1500 дугаар дүгнэлтээр 390 хувийн хэрэгт завсар оруулан зөвөтгөн мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна.

Тус аймгийн 5 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар Дэлүүн сумын улсын бүртгэгч С.Рысбай 37, Алтанцөгц сумын улсын бүртгэгч А.Бадамсүрэн 40, Улаанхус сумын улсын бүртгэгч Б.Бахитгүл 55, Алтай сумын улсын бүртгэгч Болормаа 37, Цагааннуур тосгонд Айсауле 40 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг тухайн сумын болон зэргэлдээ сумдад үзүүлсэн байна.

Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /eprs/ цахим системд ажиллах, бүртгэл хөтлөх талаар zoom-р арга зүйн сургалт зохион байгуулсан. Бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн гүйцэт авах, эх нотлох баримтыг баталгаат шудангаар хугацаанд нь хэлтсийн архивт хүргүүлж байгаа эсэхт улсын ахлах бүртгэгч тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/427 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Барьцааны гэрээ /ипотек/-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт ЭУБ-06, ЭУБ-13 маягыг үйл ажиллагаанда хэрэглэж буй тус аймагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны 5 банкны төвийн болон 13 сумын салбарын тооцооны төвүүд, 4 банк бус санхүүгийн байгууллагуудтай уулзалт, сургалт зохион байгуулж нэг мөр ойлголттой болсон.




Хүснэгт 1. 2023 оны эхний хагаст төсөвт оруулсан орлого

Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа

4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 22141 иргэн хамрагдсанаас:

Төрсний бүртгэл 1135, хүүхэд үрчлүүлсний 69, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 28, эцэг, /эх/ тогтоосны 14, гэрлэсний 187, гэрлэлт дуусгавар болсны 20, нас барсны 319, иргэний үнэмлэх олголтын 2323, үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтийн олголт 8900, биеийн давхцахгүй өгөгдлийн 2173, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 796, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 386 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголтыг 198, нөхөн бүртгэлд 72 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд нийт 5521 лавлагаа олгосон ба иргэнд 4371 лавлагаа, албан хэрэгцээнд 225 лавлагаа, хууль хяналтын байгуулагаад албан тоотоор 626 лавлагааг тус тус олгосон болно. Тайлант хугацаанд 13802 бүртгэлийн 18540 хуудас материалыг цахимжуулсан. /хүснэгт 2/



Хүснэгт 2. Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ

Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд бүртгэлгүй төрөлтийн 9, гэрлэлтийн 12, нас баралтын 1, архивын эх нотлох баримт болон лавлагааг үндэслэн төрөлтийн 22, гэрлэлтийн 26, үрчлэлтийн 1, гэрлэлт дуусгавар болсоны 1, нийт 72 иргэний мэдээллийг нөхөн бүртгэлийн журмаар бүртгэж маягтуудын “А” талыг УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтэсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор төрөлтийн 185, гэрлэлтийн 13, нийт 198 иргэнд гэрчилгээ олгов.

Регистрийн дугаар, хүйс зөрүүтэй, шүүхийн шийдвэрээр нас тогтоолгосон, төрсөн, он, сар, өдөр давхцаж олгогдсон, огт бүртгэгдээгүй зэрэг нийт 11 иргэний регистрийн дугаарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэл хийв.

Тайлангийн хугацаанд гадаад иргэний гэр бүлийн бүртгэлд нийт 13 иргэн хамрагдсанаас төрсний 10, гэрлэлтийн 3 бүртгэл бүртгэгдсэн байна

Хадгалах нэгжийн хугацаа дууссан бичиг баримтын тоог гарган УБЕГ-ын бичиг баримт нягтлан шалгах ажлын комисст хүргүүлэн, устгах баримт бичгийн жагсаалт ирүүлсэний дараа маягт болон дагалдах хуудасуудыг устгалд оруулсан.

Тайлант хугацаанд нийт 5521 лавлагаа олгосон ба иргэнд 4371 лавлагаа, албан хэрэгцээнд 225 лавлагаа, хууль хяналтын байгуулагаад албан тоотоор 925 лавлагааг тус тус олгосон болно.

Тайлант хугацаанд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 348 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд гарган өгч, ирсэн албан бичгийн дагуу 925 лавлагаа, 199 хуулбарыг гаргаж өгөв.


Шүүхийн шийдвэр, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, архивын эх нотлох баримт, лавлагааг үндэслэн нөхөн бүртгэлээр 72 бүртгэлийг хийж мэдээллийн санд тусгуулахаар маягтын А талыг ИУБГ-т хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

ИУБГ-ын даргын 2022 оын 11 дүгээр сарын 02-ны өдрийн 4/9443 тоот албан бичгээр ирсэн чиглэлийн дагуу сумдын улсын бүртгэгч нар гэрлэсний, гэрлэлт дуусгавар болны/шүүхийн журмаар/, иргэний үнэмлэхийн, биеийн давхцахгүй өгөгдлийн, шилжилт хөдөлгөөний, нас барсаны бүртгэлийг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс бүртгэж баталгаажуулан явж байгаа ба шинээр томилогдсон улсын бүртгэгч нарын бүртгэсэн бүртгэлийг тухай бүр хянаж баталгаажуулалт хийж байна

4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2023 оны эхний хагас жилийн байдлаар дараах бүртгэлүүдийг хийж гүйцэтгэв. Үүнд:

Тайлангийн хугацаанд үйлчилгээний хураамжийн орлого 41.570.047 төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого 104.296.738 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 13.884.153 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.



Хүснэгт 3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Нийтдээ 4898 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэснээс газар өмчлөх эрхийн бүртгэл 2899, газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 2087, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 1999 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.



Хүснэгт 4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Тайлангийн хугацаанд анхны бүртгэл 550, өмчлөх эрх шилжих гэрээ 587, барьцаа гэрээ 2424, бүртгэлд өөрчлөлт оруулах 341, иргэн хуулийн этгээд лавлагаа, 59 хуулбар 130 тус тус олгож, 79 хувийн хэргийг хаах бүртгэл хөтөлсөн байна.

Тайлангийн хугацаанд цахимаар нийт 2424 барцааны гэрээнд боловсруулалт хийж, 1333 барьцааны гэрээг хууль журмын дагуу боловсруулалт хийж дуусгавар болгосон байна.

Тайлангийн хугацаанд 461 бүртгэлд өөрчлөлт оруулсан бөгөөд үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгох 21, өмчлөгчийн овог, нэр, регистр өөрчлөгдөх 8, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх 34, гэмтэсэн гэрчилгээ шинээр олгох 1, газар эзэмших эрх газар өмчлөх эрх болж өөрчлөгдөх 2, эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 154, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 241 тус тус бүртгэж баталгаажуулсан байна.

Лавлагаа, хуулбар 189 хийсэн ба 79 хувийн хувийн хэргийг хаасан байна.

Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 120 лавлагаа мэдээлэлийг албан тоотоор хүргүүлэн ажилласан.


Цаашид Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчдийг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, бүртгэлийг үнэн зөв хөтлөх болон цахим системийн боловсруулалтанд анхаарч ажиллах талаар хэлстийн хурлаар анхааруулан ажиллаж байгаа бөгөөд эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой ЭХЭУБГазраас ирсэн чиглэлийг тухай бүр улсын бүртгэгчдэд танилцуулан бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 522 бүртгэл хийсэн болно. Үүнд: шинээр бүртгэсэн ТБАГУТҮГ 4, ХХК 45, НҮТББ 11, Хоршоо 4, Нөхөрлөл 9, Сан 2, ҮЭХ 1, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 112, дахин гэрчилгээ 14, нэрийн баталгаажуулалт 182 болно. 2 хуулийн этгээдийн татан буугдах бүртгэлийг бүртгэсэн. Тамга тэмдгийн 108 хяналтын дугаар олгож, ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 28 тэмдэг хурааж авсан. Е-монголиа сайтаар хуулийн этгээдийн нэр болон цахим гэрчилгээ баталгаажуулах нийт 574 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн хариу өгч ажилласан.

МУБИС болон Сэндли ХК-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын нэмэлт өөрчлөлтийг бүртгэж ажилласан.

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 44 дүрмийн хуулбар, 73 лавлагаа гаргаж өгч, 25 төрийн бус байгууллагын тайлан, Улсын бүртгэлээс хасагдахтай холбоотой хүсэлт гаргасан 51 хуулийн этгээдийн хүсэлтийг тус тус хүлээн авч цахим мэдээллийн санд бүртгэсэн болно.



Хүснэгт 5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээ

Хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд зөрүүтэй бүртгэгдсэн болон тамга, тэмдгээ үрэгдүүлсэн 6 хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч дүгнэлт гаргуулахаар Хэлтсийн хяналтын улсын байцаагчид шилжүүлэн дүгнэлт гаргуулж бүртгэсэн байна. Хувийн хэргийн эх нотлох баримтаас цахим мэдээллийн санд зөрүүтэй, орхигдож бүртгэгдсэн 4 хуулийн этгээдийн хүсэлтийг Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 806 дугаар дүгнэлтээр цахим санд засуулж ажиллав.

Тайлант хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 188 бүртгэлийн бүрдүүлбэр бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлэн ажиллав.

Шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 2 хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, шүүхэд хянагдаж буй 6 хэрэгт холбоотой хуулийн этгээдийн талаарх мэдээлэл, нотлох баримтын хуулбарыг зохих журмын дагуу гаргаж өгч ажилласан. Шүүхээр хянагдаж байгаа хэрэг маргааны судалгааг хяналтын улсын байцаагчид гаргаж өгсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны эхний 5 сарын тоон мэдээг хугацаанд үнэн зөв гаргаж, ХЭУБГ-т хүргүүлж ажиллав.

Үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр Хэлтсийн нягтлан бодогч, нярав нарт үнэн зөв гаргаж өгч ажиллаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээ, тайлан, судалгааг тогтоосон хугацаанд гаргаж удирдлагад танилцуулан ажиллаж байна. ҮАБЗ-ийг мэдээ, мэдээллээр хангах аймгийн ажлын хэсэгт тус аймагт үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн шашны болон төрийн бус байгууллагуудын талаар танилцуулга, холбогдох дэлгэрэнгүй судалгааг журамд заасны дагуу хүргүүлж ажиллав.

Хоршооны шинэчилсэн бүртгэлийн тайланг холбогдох судалгааны хамт ХЭУБГ-т хүргүүлсэн.


УБЕГ-аас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зохион байгуулсан 5 удаагийн онлайн сургалтад оролцсон. УБЕГ-ын Хүний нөөцийн нэгдсэн системд

байршуулсан Хуулийн этгээдийн хичээлийг бие даан судалж, холбогдох шалгалтыг өгч ажиллаж байна. Терроризмтой тэмцэх зөвлөлөөс зохион байгуулсан “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа” сэдэвт сургалтад оролцов.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1 дүгээр улирлын тоон мэдээ, эцсийн өмчлөгч, санхүүгийн тайлан мэдээгээ 8 улирал дараалан гаргаагүйн улмаас улсын бүртгэлээс хасагдах жагсаалтад орсон хуулийн этгээд болон иргэн, хуулийн этгээдүүд хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр цаашид анхаарах асуудлын талаар орон нутгийн радиод 3, телевизэд 1 удаа ярилцлага өгч, мэдээллийг фейсбук, сошиал сүлжээгээр 6 удаа олон нийтэд түгээн ажиллав.

ХЭУБГазар болон Хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлж тайлагнаж ажиллав.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 33 албан тоот, 3 өргөдлийг хүлээн авч хариутай албан тоот, өргөдөлд хугацаанд нь хариу хүргүүлж ажилласан болно.



4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18.7.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 1 дүгээр зүйлийн 1.4-т заасныг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн, улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулан Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийн хангуулж ажиллаж байна.

2023 оны тайлангийн хугацаанд тус хэлтэст ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн нийт 1005 иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлт мэдээллийг хүлээн

авч хууль журмын дагуу хянаж шалгаад иргэн, хуулийн этгээдэд хариу өгсөн байна. Иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, хүсэлт санал, гомдлоор 1305 улсын бүртгэлд хяналт, шалгалт хийсэн бөгөөд 786 бүртгэлд дүгнэлт гаргаж, нийт 1305 улсын бүртгэлийн зөрчлийг арилгаж хянан шийдвэрлэсэн болно. Харин 38 иргэний өргөдөл гомдол хууль заасан шаардлага хангаагүй, Хяналтын байцаагчийн шийдвэрлэх асуудал биш байсан тул 25 улсын бүртгэгчид шилжүүлсэн бөгөөд өргөдөл гомдлыг зарим хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн, татгалзаж шийдвэрлэсэн 38, иргэний өргөдлийг хуулийн шаардлага хангуулан буцаан ирүүлэх тухай шаардлага тавьж ажилласан байна. Өргөдөл, гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэн тухай бүр хуулийн хугацаанд иргэнд бичгээр хариу өгч ажилласан болно.

Тайлангийн хугацаанд тус хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасаг нийт бүртгэсэн 16979 бүртгэлийн 7161 бүртгэлд хяналт тавьж ажиллав. Үүнд: төрсний бүртгэл 636, гэрлэсний бүртгэл 187, гэрлэлт дуусгавар болсны 20, үрчилсний бүртгэл 49, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 10, овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, өөрчилсний бүртгэл 28, нас барсны бүртгэл 115, Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 16 насны иргэн 502, иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацаа дуусаж 25, 45 насны сунгалтын бүртгүүлсэн 760 бүртгэл, дахин олгосон иргэний үнэмлэх 150 бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний 1390, гадаад паспортын 2001 бүртгэл, 1115 олгосон лавлагаа, төрсний бүртгэлийн гэрчилгээ дахин олгох 185, гэрлэсний гэрчилгээ дахин олгох 13 бүртгэлд тус тус хяналт тавьж ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс 7030 гаруй бүртгэлийн нийт мэдүүлэг хүлээн авсан 4898 хөтөлсөн бүртгэл, 108 татгалзсан бүртгэлд хяналт тавьсан болно. Үүнд: газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл 375, газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 175, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих гэрээ 285, газар өмчлөх эрх шилжих гэрээ 302, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг барьцааны гэрээний 1050 бүртгэл, газар өмчлөх эрхийг барьцааны гэрээ 1000, газар өмчлөх эрхийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах 280, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах бүртгэл 181, лавлагаа, хуулбар 138, . нийт бичигдсэн газар өмчлөх эрхийн гэрчилгээ 749, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 831 олгосон үйл ажиллагаанд хяналт тавьсан, шалгасан болно.

Эд хөрөнгийн эрхийн өмчлөх эрхийн гэрчилгээ үрэгдүүлсэн 23 иргэний өргөдөл хүсэлтийг хянаж шалгаад хүчингүйд тооцох тухай дүгнэлт гаргасан байна, 5 иргэний материалыг буцаасан байна.

Тус тасагт 109 зөрчилд хоёр удаа албан шаардлага өгч, илэрсэн зөрчил гарсан алдааг цаг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч, бүртгэлийн зөрчлийг арилгах, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай шийдвэр гаргаж зөрчлийг арилгаж хамтран ажиллав.

Хуулийн этгээдийн 250 бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани 9, төрийн бус байгууллага 125, Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар 15, нөхөрлөл 3, хоршоо 8, Үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин


бүртгэсэн 14, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн 41, хуулийн этгээдийн нэр баталгаажуулах 28, тамга, тэмдэг хяналтын хуудас олгосон 15, хураан авсан тамга, тэмдэг 4 зэрэг бүртгэлд хяналт тавьсан байна. Нийт 250 бүртгэлд байнгын хяналт тавьж 102 бүртгэлд шалгалт хийсэн Хуулийн этгээдийн тамга, тэмдэг хяналтын дугаар хүчингүй болгох тухай 4 дүгнэлт гаргасан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд зохих нэмэлт өөрчлөлтийг тусгах тухай 2, бүртгэлийн зөрчил арилгах тухай 1 дүгнэлт тус тус гаргасан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн 3 хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шалгаж Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн болно.

Архивын баримтын цахимжуулалтад хяналт тавьж илэрсэн алдааг арилгаж, үнэн зөв цахимжуулах тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан иргэний улсын бүртгэлийн цахим санг цэгцлэх, тулгалт хийх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, зөрчил арилгах арга хэмжээ авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг өмнө нь буруу цахимжуулсан зөрчлийг арилган цахим санд бүртгэл хийх, бүртгэл хүчингүй болгох, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, зөрчил арилгах зэрэг 28 дүгнэлт гаргаж ажиллав.

Мөн Баян Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 тушаалын дагуу хэлтсийн Бичиг баримт нягтлан шалгах комисс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 6/3763 тоот чиглэлийн дагуу “Суат” ХХК-ний уурийн зууханд, машинаар зөөж нийт 755 ширхэг хадгаламж нэгж бүхий 188750 хуудас хувийн хэргээс тусгаарласан нотлох баримтуудыг устгалт оруулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав.

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн, үндэсний энгийн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх үрэгдүүлсэн, гэмтээсэн, иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, ашиглах, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн, үнэн зөв мэдүүлээгүй, тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д “улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2, 6, 7, 10.20 дугаар зүйлийн 1, 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 15.23 дугаар зүйлийн 1.1, 15.24 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргаж зөрчсөн 101 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэн төсөвт нийт 3425000 төгрөг оруулсан байна.

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 50 хувь буурсан үзүүлэлттэй боловч иргэний үнэмлэхийн бүртгэлд 16 нас хүрээд шинээр, 25, 45 насны сунгалтын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй зөрчил ихнэх хувь эзлэж байна. Хуулийн дагуу нэг зөрчлийн хэрэг шалгаж шийдвэрлэсэн болно. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах тогтоол 5, гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн 1 гаргасан болно.



4.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн талаар

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зохион байгуулах ажлын хэсгийн гаргасан хуваарын дагуу тус аймгийн Буянт сумын 4-р баг буюу сонгуулийн 2-7-4 хэсгийн хорооны хийгдэх ажлыг тухай бүр хийж гүйцэтгэн илтгэх хуудсаар тухай бүр ажлын хэсэгт хүргүүлэн ажиллаж байгаа болно. Нөхөн сонгууль явагдах Буянт сумын 4 дүгээр баг буюу сонгуулийн 2-7-4 хэсгийн хороонд одоогоор бүртгэлтэй байгаа 518 сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгах ажлыг тухайн сум хариуцсан улсын бүртгэгч буюу улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан С.Жаргалсайханы хамт хийж гүйцэтгэв. Сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 – 20.8 заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос эрх бүхий 6 байгууллагаас ирүүлсэн мэдээл зөв орсон эсэхийг шалгаж үзлээ. Сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байгаа оршин суугаа хаягийн бүртгэлтэй сонгуулийн насны иргэдийн мэдээлэл хэсэгт үнэн зөв бүртгэгдсэн ба сонгуулийн тухай хуулийн 20.6.3 болон 20.6.4 заасны дагуу түр хасав тэмдэглэгээ хийгдсэн 19 сонгогч байна.

Сонгуулийн тухай хуулийн 20.6.3 заасаны дагуу 60 ба түүнээс дээш хоногоор гадаад улсад зорчиж ирсэн 2 сонгогч түр хасав тэмдэглэгээг сэргээж өгөхөөр хүсэлт ирүүлсэн болно. Одоогийн байдлаар сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй сонгогчийн мэдээлэл байхгүй болно.

Д/д	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн нэр	Баг, хорооны дугаар, нэр
1	Архангай	Ут Тал	5-р баг. Тал
2	Баян-Өлгий	Буянт	4-р баг. Шар тосголт
3		Баянгол	1-р баг. Буянт
4		Баян-Овоо	1-р баг. Мандалайрван
5			2-р баг. Буянт
6			2-р баг. Гурван гол
7	Баянхонгор	Болд	3-р баг. Алтай
8			4-р баг. Буянт
9			5-р баг. Буянт
10			6-р баг. Сэрвэг
11		Зэг	2-р баг. Салы Улаан
12	Булган	Хангай	1-р баг. Сурт
13		Сэлбэр	3-р баг
14	Говьсүмбэр	Шивээговь	1-р баг
15			2-р баг
16	Дорноговь	Айраг	4-р баг. Цэцэг дөрвөлж
17		Завьт	2-р баг. Цэцэг үлэн
18	Дорнод	Чайрсан	1-р баг. Хулсай
19			4-р баг. Хөх нуур
20			5-р баг. Шөрлөг
21	Дундговь	Баяндралын	1-р баг. Сайхан гол
22		Өмнө	3-р баг. Түл
23		Хулд	1-р баг. Шивээтэй
24	Өвөрхангай	Арванхоёр	5-р баг. Равнаст
25	Ховд	Ховд	1-р баг. Ховд
26	Өвмөговь	Ногоо	2-р баг. Аюулгад
27			3-р баг. Ховд
28	Сүхбаатар	Уулзана	4-р баг. Жалынгай
29			1-р баг. Ховд
30	Сэлэнгэ	Сүхбаатар	2-р баг. Сайхан-Зүр
31		Баянхонгор	2-р баг. Буянт
32			3-р баг. Сайхан
33		Барун	2-р баг. Сайхан
34			4-р баг. Сайхан
35	Төв	Замнар	3-р баг. Сайхан
36			4-р баг. Төв
37		Өндөрцэрэл	1-р баг. Сайхан
38	Увс	Дунд	2-р баг. Зууныяла
39		Түвшин	2-р баг. Сайхан
40		Булган	2-р баг. Сайхандал
41	Ховд	Мөнхсайхан	1-р баг. Агаар
42		Завханбулаг	1-р баг. Сайхан
43	Хөвсгөл	Баянхонгор	3-р баг. Сайхан
44		Тосгонбулаг	1-р баг. Сайхан
45	Хэнтий	Баянгол	4-р баг. Ногоо
46			11-р дугаар хороо
47	Увс	Увс	11-р дугаар хороо
48			11-р дугаар хороо
49		Сүхбаатар	4-р дугаар хороо

Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

2023 оны байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр ИУБ-11 төрөлт-1126, ИУБ-12 үрчлэлт-83, ИУБ-13 овог эцэг-эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-23, ИУБ-14 эцэг тогтоолт- 16, ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл-180, ИУБ-16 гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-22, ИУБ-18 нас баралт-315, аймаг нийслэл рүү шилжин ирсэн-36, ИБЗ-1 мэдээлийн санд нөхөн бүртгэлд оруулах-86, ИУБ-31 Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-2150 буюу нийт 4037 маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. Иргэний 8-н төрлийн бүрдүүлбэр 181, гадаад паспорт мэдүүлэг 61, гаруй хадгаламж нэгж хүлээн авсан болно.

Регистрийн дугаар буруу, хүйс зөрүүтэй, ИУБ маягт нөхүүлэх МУ-санд ороогүй, нас тогтоолгох, төрөлт тогтоох, нас баралт тогтоох, шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтын бүртгэлийн зөрчлийг арилгахын тулд нийт 452 иргэний хувийн хэргийг Архивын фондоос захиалгын хуудсаар бүртгэл хөтөлж Улсын бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт гаргаж өгөх хүлээн авч буцаан байрлуулан ажиллав.

Хадгалах нэгжийн хугацаа дууссан бичиг баримтын тоог гарган УБЕГ-ын бичиг баримт нягтлан шалгах ажлын комисст хүргүүлэн, устгах баримт бичгийн жагсаалт ирүүлсэний дараа маягт болон дагалдах хуудасуудыг устгалд оруулсан.

Тайлант жилийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 561 хувийн хэргийг шинээр архивт хүлээж авч шинээр нээсэн хувийн хэрэг бүртгэх маягт дэвтэрт бүртгэж улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу хаяглаж архивт байршуулсан болно.



Үүнд: газар өмчлөлийн анхны бүртгэл 181, газар эзэмших 4877, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэл 380, ашиглах эрхийн 2 хувийн хэрэг орсон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар бүртгэл нь хүчингүй болж хаагдсан 77 хувийн хэрэг байна.

Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутам хүлээж авсан нэмэлт өөрчлөлт, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өв залгамжлах гэрээ, барьцааны гэрээ, лавлагаа, хуулбар зэрэг нийт 4600 гаруй нотлох баримтуудыг архивт хүлээж авч хувийн хэргийн байжилтыг цаг тухайд нь хийж байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 34110 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүний: 15891 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 13628 нь газар өмчлөл, үлдсэн 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, 6 нь ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн 77 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу байршуулсан болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид бүтэн жилийн хугацаанд 248 гаруй хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч цаг тухайд нь зохих журамын дагуу байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2485 хувийн хэрэг хадгалагдаж байна.



Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна. Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна.

ХЗДХЯ-ны салбарын цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем “E-DOC” <https://edoc.mojha.gov.mn/> программыг хэрэглээндээ бүрэн нэвтрүүлэн ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд /2023.06.08-ны өдрийн байдлаар/ хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 581 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 715 албан бичиг гадагш явуулсны 476 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хагас жилийн байдлаар хэлтсийн даргын “А” тушаал 8, “Б” тушаал 3, нийт 11 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

2023 оны 06 дугаар сарын 08-ны байдлаар нийт 131 иргэний өргөдлөөс 128 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 3 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 97.7%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа болно. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг Хэлтсийн 70427810, 70427766 дугаарын утсаар авч ажиллаж байна.

Өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгт дагуу гаргаж, улирлын сүүлийн сарын 15-ны дотор УБЕГ-ын Тамгын газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн <https://bayan-ulqii.burtgel.gov.mn/> цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.

Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд /


Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн цахим хуудас нь <https://bayan-ulqii.burtgel.gov.mn/> гэсэн хаягтай. Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааг тус цахим хуудсанд 30 мэдээлэл байршуулсан ба олон нийтэд түгээх зорилгоор мэдээллийг фото зургийн хамт олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulqii.burtgel> фэйсбук пэйж хуудсаар мэдээллийг давхар түгээж ажилласан байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан шэйр хийж байна. Өнөөдрийн байдлаар 3300 дагагчтай болсон байна. 2023 онд социал хуудсаар дамжуулан 117 бүртгэлтэй холбоотой мэдээлэл түгээсэн байна.

Цахим хуудасны танилцуулга цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, ил тод цонхонд хүний нөөцийн ил тод байдал, шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, хэрэглэгч танд цонхонд түгээмэл асуулт хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, холбоо барих цонхонд байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудан хаяг зэргийг нээлттэй байршуулсан болно. <https://bayan-ulqii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

Нүүр хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зургийг бүрэн оруулсан. Баннер хэсэгт төрийн үйлчилгээний E-mongolia цахим систем, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах Burtgel.mn систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээлэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.

Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google тар дахь газрын байршилыг харуулсан болно.



Тус Хэлтэс нь батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 оны эхний 06 сарын байдлаар улсын төсвөөс 277.757.000 төгрөг, нэмэлт санхүүжилтээр УБЕГазраас АНСДИТХ-ын дахин сонгуулийн бэлтгэл ажилд 5.259.0000 төгрөг, нийт 283,016,000 төгрөгийн санхүүжилт авснаас 275.733.200 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, ба энэ нь нийт төсвийн 97.4% байна. Мөн тайлант хугацаанд 58.333.333 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 71.475.556 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 68.004.067. төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 127.7%-иар биелүүлсэн болно. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээг УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон үлдэгдлийн тайлан, иргэний үнэмлэхийн орлогын тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлж байна. Мөн түүнчлэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хуулийн хугацаандаа хүргүүлсэн. Хэлтсийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж “Зөрчилгүй” дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүд болох тухай бүр оруулах 40 ш, сар бүр оруулах 25, улирал бүр оруулах 2 мэдээллүүдийг хуулинд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж, үлдэгдэл үнэт цаасыг тулган ажилласан.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2023 оны төсөв болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-05 дугаар сарын мэдээнүүдийг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан. Мөн 11 сарын байдлаар Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 24.397.500 төгрөгийн үнэт цаас бараа материал 35.629.846 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хүлээн авч санхүүгийн тайландаа тусгасан болно. Хэлтсийн эд хөрөнгийн тооллогыг хэлтсийн даргаар тушаал гаргуулан хуулийн хугацаанд хийж гүйцэтгэх ажлыг ханган ажиллаж байна.


Найм. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн албаны зөвлөл, Бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан зохион байгуулсан сургалтад албан

хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 55 удаагийн сургалтад давтагдсан байдлаар 224 албан хаагч хамрагдсан байна. Хэлтсийн 2023 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, баталуулан, төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурталчилах зорилгоор нийт 5 сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд 7 дотоодтой, 5 бусад байгууллага, албан тушаалтан нартай хамтран зохион байгуулав. Хүний нөөцийн сургалтын системийн Бие даан хийх хичээлийн хэсгийг улсын бүртгэгч нарт судлуулан шалгалтыг нь өгч ажилласан болно.

Дотооддоо дараах сургалтуудыг зохион байгуулав.

- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ сэдэвт албан хаагчдын ёс зүй, хандлага, хариуцлагыг сайжруулах сургалт
- Эрүүл мэндийн газартай хамтран "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" сургалт
- Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран 150 гаруй албан хаагч нарт "Хүний эрх, төрийн албан хаагчийн эрх, үүрэг хариуцлага" сэдэвт сургалт
- Өөрийгөө ургуулах 5 дадал
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн тухай ойлголт
- Гамшгаас хамгаалах арга хэмжээ, галын аюулгүй байдлыг хангах, галын аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх
- Төрийн албан хаагчийн ёс зүйн ба улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт
- Улсын бүртгэлийн байгууллагын хууль тогтоомж болон холбогдох бусад хуулийн талаар ойлголт



Төрийн удирдлагын академийн сургалтын систем дэх Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа – 2050” сэдэвт богино хугацааны 40 цагийн цахим сургалтад нийт алын хаагчид хамрагдаж сертификат авсан болно.



Ес. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль эцэслэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар тус хэлтсээс 41,801 иргэн тоон гарын үсгээ авсан байна.


Энэ нь Баян-Өлгий аймгийн 16-аас дээш насны нийт иргэдийн 60 хувьд олгосон байна.

Нэгжийн нэр	2023/01 сар	2023/02 сар	2023/03 сар	2023/04 сар	2023/05 сар	2023/06 сар	Нийт тоо
Баян-Өлгий хэлтэс	194	66	59	2,084	1,887	38	4328
Баян-Өлгий, Баяннуур	278	210	97	763	462	32	1842
Баян-Өлгий, Алтанцөгц	125	46	49	218	112	24	574
Баян-Өлгий, Ногооннуур	390	151	109	400	358	41	1449
Баян-Өлгий, Алтай	483	130	6	48	0	0	667
Баян-Өлгий, Цэнгэл	82	20	60	451	470	92	1175
Баян-Өлгий, Дэлүүн	239	36	52	350	245	6	928
Баян-Өлгий, Толбо	24	15	4	171	0	0	214
Баян-Өлгий, Буянт	353	71	39	198	167	22	850
Баян-Өлгий, Улаанхус	467	15	37	177	246	30	972
Баян-Өлгий, Цагааннуур	83	53	32	156	78	18	420
Баян-Өлгий, Булган	48	1	20	207	459	26	761
Баян-Өлгий, Өлгий	12	12	1	550	2,500	93	3168
Баян-Өлгий, Сагсай	37	31	66	533	146	31	844
Баян-Өлгий, Бугат	214	135	32	131	61	23	596
Нийт тоо	3029	992	663	6437	7191	476	18788

Хүснэгт 8. Нэгжүүдийн тоон гарын үсэг олголтын тоон мэдээ

Тоон гарын үсэг олголтыг УБЕГ-аас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу эрчимжүүлэх ажлын хүрээнд бүх албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд албан бичиг хүргүүлэн, радио, телевизд ярилцлага өгч, томоохон аж ахуй нэгж албан байгууллагуудад очиж тоон гарын үсэг олгох, сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газар Хаан банктай хамтран зохион байгуулж буй Тоон гарын үсгийн олголтыг идэвхжүүлэх аяны хүрээнд тус хэлтсээс албан байгууллага, аж, ахуйн нэгжүүд болон Ерөнхий боловсролын сургуулиудад тоон гарын үсэг олгож, мэдээлэл өгч ажиллав.



Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулах ХААН банк ХХК санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ, онлайн зээлийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг болсонтой холбогдуулан аймгийн төвийн сум болох хамгийн их хүн амтай Өлгий сумын Засаг даргатай хамтран багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудын дунд “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян” зохион байгуулсан.

Батлав:
Өлгий сумын Засаг дарга
бөгөөд хотын Захирагч
Д.Есболат

Батлав:
Улсын бүртгэлийн
хэлтсийн дарга
Х.Амангүл

**"Тоон гарын үсэг олголтыг
идэвхжүүлэх аян"-ы удирдамж**

ЗОРИЛГО: Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талварх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг хамтран зохион байгуулах Хаан Банк ХХК санхүүгийн бүх төрлийн гүйлгээ онлайн зээлийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг болсонтой холбоотой банкны бүтээгдэхүүн үйлчилгээнд тоон гарын үсэг болон qr code аппликейшний хэрэглээг нэмэгдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Монгол улсын 16 ба түүнээс дээш насны иргэд
Үргэлжлэх хугацаа: 2023.05.05-2023.06.05 дуустал
Гарах үр дүн:

- Иргэний үнэмлэхний санах ой буюу чипэнд суулган олгох тоон гарын үсгийн тоог 10.000 хүргэх
- qr code апп буюу гар утасны аппликейшнээ дамжуулан олгох тоон гарын үсгийг иргэдэд заан сурталчлах
- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээнд тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх.

Хамтран ажиллах чиглэл:

- Нийгэд чиглэсэн уриа үг
- Байгйн иргэдэд тоон гарын үсэг олгох өдөрлөг зохион байгуулах.
- Байгйн засаг дарга, нийгмийн ажилтнуудын дунд уралдаан зарлах.
- Монгол улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг идэвхжүүлэх.

Багуудад өдөрлөг зохион байгуулах хуваарь

№	Баг	Эхлэх өдөр	Дуусах өдөр
1.	1-р баг "Хуст арал"	2023.05.05	2023.05.08
2.	2-р баг "Цагаан эрэг"	2023.05.09	2023.05.10
3.	3-р баг "Бөхөн уул"	2023.05.11	2023.05.12
4.	4-р баг "Их булан"	2023.05.12	2023.05.15
5.	5-р баг "Хөвд гол"	2023.05.16	2023.05.17
6.	6-р баг "Хөх толгой"	2023.05.18	2023.05.19
7.	8-р баг "Жаргалант"	2023.05.22	2023.05.23
8.	9-р баг "Хөх хад"	2023.05.24	2023.05.25
9.	10-р баг "Харсай"	2023.05.26	2023.05.29
10.	11-р баг "Бүргэд"	2023.05.30	2023.05.31
11.	12-р баг "Ногоон төгөл"	2023.06.01	2023.06.02
12.	13-р баг "Шинэ айл"	2023.06.05	2023.06.06

"Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян"-д иргэдэд идэвхтэй хамруулсан багт дараах мөнгөн шагналыг олгоно.

1-р байр -150.000 /нэг зуун тавин мянган/ төгрөг.
2-р байр -100.000 /нэг зуун мянган / төгрөг.
3-р байр -50.000 /тавин мянган/ төгрөг.

Арав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн ИТХ, Засаг даргад тус хэлтэст тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал хүргүүлж, ОНХС хөрөнгөөр 10 сая төгрөг шийдвэрлүүлэн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж, техникийн тодорхойлолтод заасны дагуу хэлтсийн даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/07 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авсан.

- Тоног, төхөөрөмж худалдан авах 10.000.000 төгрөг

№	Нэр төрөл	Тоо, х/ж	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Монитор	1ш	659.900	659.900
2	Компьютер	1ш	2.299.900	2.299.900
3	Ноутбук	1ш	2.500.000	2.500.000
4	Сканнер	2ш	2.270.100	4.540.200
	Нийт дүн			10.000.000




“Цахим засаглал” хөтөлбөр, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх ажлын хүрээнд сумдын Засаг дарга, удирдлага нартай хамтран ажиллаж, санал хүргүүлснээр орон нутгийн хөгжүүлэх сангаас

- Дэлүүн сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 7.000.000 төгрөг
- Ногооннуур сум цахим төлбөрийн Гэрэгэ Киоск машин 7.000.000 төгрөг
- Цэнгэл сум цахим төлбөрийн Гэрэгэ КИОСК машин 5.000.000 төгрөг
- Улаанхус сум сүлээжээний роутер 600.000 төгрөг

Нийт орон нутгийн төсвөөс 19.700.000 /хорин ёсөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлсэн байна. Тайлангийн идэвх санаачлага хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

Аймгийн удирдах ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөнд /сумдын Засаг дарга нар/ оролцож Улсын бүртгэлийн хууль тогтоомж, бүртгэлийн үйлчилгээ болон Тоон гарын үсгийн ойлголт, хэрэглээний талаар мөн төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, чийрэгдэлгүй хүргэхэд манай байгууллагатай байнга хамтран ажиллаж Улсын бүртгэлийн КИОСК машин, төлбөр тооцооны ПОС машин шийдвэрлэж өгсөн сумдын удирдлагууддаа баярлаж талархсанаа илэрхийлэв.



Аймгийн Засаг даргаар ахлуулсан баг өвөлжилтийн нөхцөл байдал болон төрийн үйлчилгээний хүртээмжтэй танилцах зорилгоор сумдад ажиллаж, ажлын хэсэгт тус хэлтэсийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нарыг хувиарлан оролцуулж ажилласан болно.




“Хуульчийн про боно өдөр”, “Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” өдөрлөгийн үеэр аймгийн төв талбайд НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ зохион байгуулагдаж уг арга хэмжээнд тус хэлтсийн холбогдох албан хаагчид оролцож Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээ, лавлагаа мэдээллийг цахимаар авах, тоон гарын үсгийн хэрэглээний талаар заавар, зөвлөгөө болон залуу хосуудад гэрлэлтийн гэрчилгээ өгч ажиллав.



Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг олон нийтэд таниулах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тогмтол ярилцлага өгч, албан байгууллагуудад мэдээллийн цаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сумдын улсын бүртгэгч нар БИНХ-д оролцож мэдээлэл өгч ажиллав.



Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нутгийн төрийн захиргааны байгууллагын хууль тогтоомжийг Орон нутгийн Саян, Дербес телевиз, олон нийтийн радио, МОНЦАМЭ агентлагаар сурталчлах баталсан график төлөвлөгөөний дагуу иргэдэд мэдээ мэдээлэл 12 удаа ярилцлага өгсөн болно.



Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулсан ба тус шалгалтад орохоор бүртгүүлсэн иргэдийг Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр /хуруу хээ/ таниулан шалгалт өгөх эрхийг баталгаажуулан хамтран ажилласан болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “НАУРЫЗ” баярыг угтан зохион байгуулсан төрийн байгууллагуудын “Ажилтан, албан хаагчид үндэсний хувцсыг сурталчлах” уралдаан, “Наурыз”-ын баярын өдрийн парадад “ХҮҮХЭД ӨЛГИЙДЭХ” зан заншилыг ёслол төгөлдөр үзүүлэн оролцов.



Наурыз баярыг тохиолдуулан ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулагдсан "ҮНДЭСНИЙ ХУВЦСЫГ СУРТАЛЧЛАХ" цахим уралдаанд бусдыгаа манлайлан амжилттай оролцож II байр, баярын хүндэтгэлийн жагсаалд III байр эзлэн "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ", мөнгөн шагналаар шагнагдлаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай Гэр бүл, хүүхэд, залуучуудын талаар төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

- Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжил оролцоог дэмжсэн сургалт, мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлэх,

- "Хүүхэд хамгааллын бодлого" боловсруулж, хэрэгжүүлэх, .

- Залуучуудын хувь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, аюулгүй амьдрах хөгжих орчин нөхцлийг дэмжих чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх "ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ" байгуулан ажиллаж байна.



Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригт үндэсний мод тарих өдөр хэмээн 🌲🌲🌲 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж уг зорилтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор өнөөдөр хуваарьтай газарт хэлтсийн ажилтан, албан хаагчид мод тарих ажлыг зохион байгууллаа.



Улсын хэмжээнд 2023 оны 06-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт “Зарлан мэдээллийн дохио” нэгэн зэрэг дуугарч, иргэд, ажилтан албан хаагчид, төв талбай болон албан байгууллагынхаа аюулгүй талбайд цугларах дадлага сургуулилтыг хийж, хэлтсийн албан хаагчид аюулгүй талбайд цугларав.

Энэ удаагийн сургуулилтаар болзошгүй гамшигт хэр бэлэн байдалтай байгаа вэ гэдгээ шалгаж, байгууллага хороодын уялдаа холбоо, гамшигтай тэмцэх бэлэн байдал, газар хөдлөлтийн давтамж ихэссэн цагийн байдлын үед ямар арга хэмжээ богино хугацаанд авч хэрхэн хохирол багатай даван туулахад чиглэсэн ажлууд хийгдлээ.



Арван нэг. Идэвх санаачлага, шинэлэг ажил


Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим үндэстэн болох хөтөлбөрийн хүрээнд хийж байгаа Монгол Улсын иргэний энгийн гадаад паспортыг цахимжуулж Улсын бүртгэлийн байгууллагууд нэгэн зэрэг цахим гадаад паспортыг олгож эхэлсэн. Уг ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэст нээлтийн арга хэмжээ болж, анхны Үндэсний энгийн цахим гадаад паспортыг эзэдэд нь гардуулан өгсөн.

Монгол улс ИКАО-ын гишүүн орныхоо хувьд ИКАО-ын Нийтийн түлхүүрийн санд 82 дахь гишүүн орноор элсэн орж, үндэсний энгийн цахим гадаад паспортыг иргэддээ олгоод байна.



Цахим гадаад паспорт нь зөвхөн тусгай зориулалтын төхөөрөмжид уншигдах бөгөөд та хилийн шалган нэвтрүүлэхээр хилээр орсон гарсан тамга даруулалгүйгээр тусгай төхөөрөмжид уншуулан богино хугацаанд хилээр нэвтрэх боломжтой.


Өнөөдрийн байдлаар тус хэлтэст цахим гадаад паспортыг 543 иргэнд олгосон байна. 2023 оны 01-р сараас эхлэн гадаад паспортын захиалга эрс нэмэгдсэн. Тайланд хугацаанд 8900 иргэнд гадаад паспорт олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 дахин нэмэгдсэн байна. /**график 6**/



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн өргөтгөсөн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гадаад паспортын захиалгыг хурууны хээгээр авч хэвшсэн. Хурууны хээ уншихгүй байгаа иргэдийг регистрийн дугаараар авч, улсын ахлах бүртгэгчээр хянуулан бүртгэл хөтөлж байна.

2022 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АУДИТ ХИЙЛГЭЖ ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ АВСАН.

Төсвийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлийн 2022 оны аудитын дүгнэлтээр акт, албан шаардлага, зөвлөмжгүй ажиллаа.



“ҮЛГЭР ЖИШЭЭЧ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” сэдэвт 14 хоногийн аяны өрнүүлж, шилдэг албан хаагчдаа шалгаруулсан.



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС